

2023 оны үйл ажиллагааны тайлан

2024 оны 2-р сар

БАТЛАВ: “ГУТАЛ” ХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ц.ТӨМӨР

1. БИЗНЕСИЙН МОДЕЛЬ, СТРАТЕГИ

Бизнесийн чиглэл

Оффис, агуулах, гараж болон үйлдвэр үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйлчилгээ.

Компанийн танилцуулга

Тус компани нь 1992 онд “Гутал” ХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдаж, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэгт байрлах оффис, агуулах болон үйлдвэр, үйлчилгээний зориулалттай объектуудыг түрээслүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

Тус компанийн үл хөдлөх эд хөрөнгө нь үйлдвэрийн барилга, гуанзны барилга, эмнэлгийн барилга, бусад жижиг барилгууд бүртгэлтэй байна. 2023 онд манай үйл ажиллагаа хэвийн нэг түвшинд явагдаж өнгөрлөө.

Санхүүгийн байдал

“ГУТАЛ”ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн ажлыг “ФИНАНСТАКС ТМЗ” ХХК 2018 оны 8-р сараас одоог хүртэл хариуцан ажиллаж ирлээ.

Компанийн үйлчилгээний борлуулалтын орлого, тэдгээртэй уялдан гарах бизнесийн үйл ажиллагааны зардлыг харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээ хэлцлийн дагуу сараар тооцож тайландаа тусгадаг билээ.

2023 оны компанийн үйл ажиллагаанаас олсон цэвэр ашгийн хэмжээ өнгөрөгч оныхоос 43.6 сая төгрөгөөр буурсан байна.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт /сая төгрөг/	2020	2021	2022	2023
Эргэлтийн хөрөнгө	4,445.9	5,479.9	4,619.7	5,530.2
Эргэлтийн бус хөрөнгө	8,322.6	8,036.9	7,332.2	6,905.0
Нийт хөрөнгийн дүн	12,768.5	13,516.8	11,951.9	12,435.2
Өр төлбөр	816.1	967.5	1,345.2	1,531.8
Эзэмшигчийн өмч	11,952.4	12,549.3	10,606.7	10,903.4
Нийт ӨТ ба ЭӨ-ийн дүн	12,768.5	13,516.8	11,951.9	12,435.2

Өр төлбөр ба эзний өмч 14.0% ба 86.0% харьцаатай байна.

Орлогын тайлангийн үзүүлэлтүүд

2023 оны гүйцэтгэлээр нийт 6,445.5 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Орлогын төрөл	2022	2023	Өсөлт +/-, бууралт -/	
			дүнгээр	хувиар
Түрээсийн орлого	5,515.7	6,387.9	872.2	15.8
Хүүгийн орлого	44.2	57.0	12.8	29.0
Бусад	10.0	0.6	-9.4	-94.1
Дүн	5,669.9	6,445.5	875.6	15.7

Тайлант жилд компани 3,423.5 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан нь өмнөх оноос 279.9 сая төгрөгөөр бага байна. Түрээсийн орлого өмнөх оноос 872.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2023 онд нэгж талб

2022	2023	Өсөлт +/-, бууралт -/	
		дүнгээр	хувиар
5,515.7	6,387.9	872.2	15.8
44.2	57.0	12.8	29.0
10.0	0.6	-9.4	-94.1
5,669.9	6,445.5	875.6	15.7

айн түрээсийн үнэлгээг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Үзүүлэлт /сая төгрөг/	2022 он	2023 он	Өсөлт +/- Бууралт -/	Хувиар %/
Нийт орлого	5,669.9	6,445.5	875.6	15.7
Нийт зардал	2,102.8	3,022.0	919.2	43.7
Татварын дараах цэвэр ашиг	3,467.1	3,423.5	-43.6	-1.2

Төлсөн татвар, шимтгэл

Тайлант жилд нэмэгдсэн өртгийн албан татварт 506.7, Нийгмийн даатгалын шимтгэлд 140, Хувь хүний орлогын албан татварт 50,3, суутгагчийн хувь хүнээс суутгасан албан татварт 150, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 88,3, газрын төлбөрт 52.8, нийт улс, орон нутгийн төсөвт 988.1 сая төгрөгийн татвар хураамж төлсөн байна.

Төрөл /сая төгрөг/	2017	2018	2019	2020	2021	2022	2023
НӨАТ	302.0	435.7	341.4	303.8	330.2	459.8	506.7
НДШ	103.0	101.9	105.4	46.3	98.4	129.5	140
ХХОАТ	526.0	224.4	160.3	144.1	129.7	272.5	200.3
ААНОАТ	230.0	267.5	276.3	118.0			

ҮХЭХАТ	93.0	66.8	79.4	79.6	92.9	87.6	88.3
Нийт дүн	1,254.0	1,096.3	962.8	691.8	651.2	1,008.6	988.1

2. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомжинд нийцүүлэн явуулсаар ирсэн бөгөөд одоо ч энэхүү зарчимаа алдаагүй явуулж байна. Дэд бүтцийн хувьд цахилгаан, дулаан, ус, хот тохижилтын төвлөрсөн системд бүрэн холбогдсон учир эдгээр байгууллагуудтай аж ахуйн гэрээ байгуулан үйл ажиллагаагаа уялдуулан, мөрдөж буй норм нормотивыг баримтлан ажиллаж төлбөр тооцоог цаг тухайд нь хийж байна.

Нийгмийн халамжийн асуудлаар холбогдох хууль тогтоомж, компанийн ТУЗ-ийн шийдвэрийг баримтлан тодорхой төлөвлөгөөтэй ажил зохион явуулахаар төлөвлөн хэрэгжүүлж ирлээ. Эдгээртэй холбогдон гарч буй зардлыг санхүүгийн төлөвлөгөөнд бүрэн тусгасан болно.

3. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЗҮГЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

2023 онд түрээсийн нийт талбайн үнийг 15 % хүртэл нэмж, нэмэгдсэн түрээсийн төлбөрийг саадгүй төлүүлж байгаа.

Мөн олон жилээр компанийн дотоод хэрэгцээнд ашигладаг байсан зоорь, подвалыг суллан, засварлаж түрээсийн талбайг нэмэгдүүлсэн.

2023 онд удирдлагын зүгээс авч хэрэгжүүлсэн ажлуудаас дурдахад:

- Оффисын 7 давхар барилгын паарыг 1-7 давхар хүртэл бүхэлд нь шинэчилсэн.
- Оффисын барилгын В1 давхарт олон жижиг тасалгаа байсны ханыг нураан засварлаж автомашин орох орц, гарцыг шинээр хийж зал болгон агуулахаар түрээслүүлсэн.
- Аж ахуйн хашааны хэрэглэдэггүй байсан газрын шороог тэгшлэн бетондож дээр нь 242 мкв, 121 м.кв бүхий хоёр агуулах барьсан.
- Гараж №12,13,14,15,16,17,18,19,20,21,22 -н дээврийг шинэчилж засварласан.
- ТЗ-н 8 том агуулахын үүдээр шинэ засмал зам тавьсантай холбогдуулан гадна фасадыг засварлаж, дээврийг бүхэлд нь будаж янзалсан.
- ТЗ-н 1-9 дүгээр агуулахуудын галын дохиоллыг шинэчилсэн.
- ТЗ-н 1, 2 дугаар агуулахуудад дотор засвар хийж сайжруулсан.
- Жижиг агуулах, гаражуудын гадна болон дотор урсгал засварыг хийж гүйцэтгэсэн


Мөн түрээслэгч байгууллагууд болон компанийн ажилчдын ая тухтай орчныг бий болгохыг эрхэмлэн тохижилт, засвар үйлчилгээг цаг тухайд хийж түрээслэгчдийн эрхийг хангахын төлөө хичээн ажиллаж байна.

4. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

“ГУТАЛ” ХК нь 2023 онд захиргааны албанд 5, инженер техникийн албанд 9, аж ахуй барилгын албанд 6 , харуулын албанд 9 нийт 29 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулахаар төсөвлөсөн.

2023 онд ажилчдын ажлын үр дүнг сайжруулах, орон тооны илүүдлийг бууруулах зохистой арга хэмжээ авснаар цалингийн зардлын хэмжээг тодорхой хэмжээгээр хэмнэж ажилласан.

**ГУТАЛ ХК-ИЙН БҮТЭЦ ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ**



ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

ТУЗ-Н НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ЖАРГАЛ

О.МАРАЛ-ЭРДЭНЭ